

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн



ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлуудын чанар, үр дүн хангалтгүй, СХС-гаас олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 84.6% нь чанаргүй зээл байна.

2018 он

АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа</p> <p>Аудитын менежер Г.Наранбаяр</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан</p> <p>Аудитор М.Ундармаа</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон, 2 давхар, 208 тоот</p>	<p>Товчилсон үгийн тайлбар4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p>НЭГ. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын чанар, үр дүн хангалтгүй байна.</p> <p>1.1. ОНХНС болон аймгийн ОНХС-гаас батлагдсан орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.</p> <p>1.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.</p> <p>1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын дагуу үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй байна.</p> <p>ХОЁР. Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй, түүнд тавих хяналтыг дүнтэй хэрэгжүүлээгүй байна.</p> <p>2.1. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулалт, зээлийн гэрээний биелэлт, хөрөнгийн эх үүсвэрийг журамд заасны дагуу төлөвлөөгүй, зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлэх ажил хангалтгүй байна.</p> <p>2.2. Нийт зээлийн үлдэгдлийн 84.6%-ийг чанаргүй зээл эзэлж байгаа нь сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүйг харуулж байна</p> <p>2.3. СХС-ийн орон тооны бус зөвлөл журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p>2.4. СХС-ийн журамд зээл болон барьцааны гэрээ, хүү төлбөрийн хуваарь, хяналтын хуудас, тайлан гаргах загвар зэргийг баталж мөрдүүлэх, мөн хариуцлагын талаар тодорхой тусгах шаардлагатай байна.</p> <p>ГУРАВ. Өмнөх онд хийгдсэн аудитаар ОНХС болон СХС-д өгсөн зөвлөмж, актын хэрэгжилт хангалтгүй байна.</p> <p>3.1. Өмнөх оны аудитаар аймгийн ОНХС-д өгөгдсөн зөвлөмж 47.0%, акт, албан шаардлагын биелэлт 67.7%-тай байна.</p>
---	---

3.2. Өмнөх аудитаар СХС-гуудад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, хууль тогоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон АИТХ, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээл ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагнал, аймаг, сумдын ИТХ болон аймгийн СТСХ, ХОХБТХ, холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан Нийцлийн аудитын журмын дагуу Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтод арга хэмжээнээс түүвэрлэн горим сорил хэрэгжүүллээ.

4. Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа нар хийж гүйцэтгэлээ.

5. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

6. Үндсэн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2017 онд ОНХС-д нийт 2,975,959.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж ажилласан байна. Үүнд: өмнөх оны үлдэгдлээс 793,182.9 мянга, ОНХНС-гаас 1,178,802.1 мянга, 2016 оны үндсэн тэнцлийн ашгаас 798,871.5 мянга, орон нутгийн давсан орлогоос 197,052.0 мянга, үйл ажиллагааны орлогоос 8,771.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал

/мянган төгрөгөөр/

Сангийн нэр	Өмнөх оны үлдэгдлээс	ОНХНС-гаас	Татварын давсан орлогоос	2016 оны үндсэн тэнцлийн ашиг	Орлогоос	Нийт
Аймгийн ОНХС	524,505.4	589,915.9	197,052.0	731,832.9	8,771.4	2,052,077.6
Сүмбэр сумын ОНХС	37,375.6	386,355.0		49,944.7		473,675.3
Шивээговь сумын ОНХС		156,561.7		14,709.2		171,270.9
Баянтал сумын ОНХС	231,301.9	45,249.5		2384.7		278,936.1
Нийт дүн	793,182.9	1,178,082.1	197,052.0	798,871.5	8,771.4	2,975,959.9

Хүснэгтээс харахад: Нийт эх үүсвэрээс АОНХС 69% буюу 2,052,077.6 мянга, Сүмбэр сумын ОНХС 16% буюу 473,675.3 мянга, Шивээговь сумын ОНХС 6% буюу 171,270.9 мянга, Баянтал сумын ОНХС 9% буюу 278,936.1 мянган төгрөг байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

ОНХС-гийн нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
Аймгийн ОНХС	2,052,077.6	1,464,469.3	587,608.3
Сүмбэр сумын ОНХС	473,675.3	420,607.1	53,068.2
Шивээговь сумын ОНХС	171,270.9	160,496.0	10,774.9
Баянтал сумын ОНХС	278,936.1	254,578.8	24,357.3
Нийт дүн	2,975,959.9	2,300,151.2	675,808.7

Хүнэгтээс харахад: Аймгийн ОНХС-гийн хэмнэлт нь өмнөх оны дутуу ажлын санхүүжилт 16,407.4 мянга, 2017 оны дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилт 8,400.0 мянга, 2017 онд хэрэгжээгүй, он дамжин хийгдэх ажлын үлдэгдэл санхүүжилт 538,400.0 мянга, хөтөлбөр төсөл, арга хэмжээний хэмнэлт 23,833.0 мянга, 2017 оны ажлын гэрээний хэмнэлт 567.9 мянга, нийт 587,608.3 мянган төгрөг байна.

Сүмбэр сумын ОНХС-гийн хэмнэлт нь 2 ажлын барьцаа хөрөнгө 5,815.4 мянга, 23,053.4 мянга, он дамжсан ажлын үлдэгдэл санхүүжилт 8,921.2 мянга, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын гэрээний хэмнэлт 15,278.2 мянга, нийт 53,068.2 мянган төгрөг байна.

Шивээговь сумын ОНХС нь сумын ИТХ-ын 2017.12.19-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор гэрээний хэмнэлт 10,774.9 мянган төгрөгөөр 3 ажил хийхээр баталсан боловч ондоо багтаж хэрэгжээгүй байна.

Баянтал сумын ОНХС-гийн үлдэгдэл нь өргөх станцын зураг төсвийн санхүүжилт 7,000.0 мянга, 2-р багийн төвийн барилгын зураг төсвийн санхүүжилт 2,400.0 мянга, 2-р багийн төвийн барилгын зураг төсвийн гэрээний хэмнэлт 3,200.0 мянга, зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр хэрэгжээгүй үлдэгдэл 2,069.0 мянга, 4 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажлын 188.3 мянга, өмнөх оны шинээр худаг барих ажлын дутуу санхүүжилт 9,500.0 мянга, нийт 24,357.3 мянган төгрөг байна.

Сумдын Сум хөгжүүлэх сангийн хувьд:

2017 оны жилийн эцсийн байдлаар 176 зээлдэгчийн 945,268.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдэл нь үйлчилгээний зориулалттай 70 иргэний 480,456.4 мянга, үйлдвэрлэлийн зориулалттай 84 иргэний 386,737.1 мянга, худалдааны зориулалттай 22 иргэний 78,069.8 мянган төгрөгийн зээл тус тус байна.

2017 оны байдлаар зээлийн үлдэгдлийн 84.6% буюу 800,170.2 мянган төгрөгийн чанаргүй зээл байгаагаас чанаргүй зээлийн 31.0%-ийг шүүхэд шилжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Бүлэг 1

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын чанар, үр дүн хангалтгүй байна.

1.1 ОНХНС болон аймгийн ОНХС-гаас батлагдсан орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.1 Аймгийн ОНХС-гаас сумын ОНХС-д олгох шилжүүлгийг Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу үнэн зөв тооцоолсон байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 07 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,185,395.0 мянган төгрөгийн шилжүүлгийн орлогыг авахаар төлөвсөн боловч гүйцэтгэлээр 1,178,082.1 мянган төгрөгийн шилжүүлгийн орлого авсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	ОНХС-гийн орлогын эх үүсвэрийн нэр, төрөл	ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийн		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1.	Дотоодын барааны НӨАТ-ын 5%	601,833.2	601,833.2	0.0
2.	Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%	249,716.0	249,716.0	0.0
3.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хуваарилалтын 5%	84,675.2	84,675.2	0.0
4.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мега төслийн 10%	80,284.2		80,284.2
5.	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50%	168,886.4		168,886.4
6.	ОУ-ын байгууллагаас сумдын ОНХС-д олгох урамшуулал		241,857.7	-241,857.7
Нийт дүн		1,185.395.0	1,178,082.1	7,312.9

Хүснэгтээс харахад: ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг гүйцэтгэлээр 7,312.9 мянган төгрөгөөр дутуу олгогдсон байна. Тухайлбал: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мега төслийн 10%, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50%-ийг орлогыг хуваарлалтыг 2020 он хүртэл хойшлуулснаас 249,170.6 мянган төгрөг хасагдаж, Олон улсын байгууллага буюу “Тогтвортой амжиргаа-III” төслөөс сумдад олгогдсон 241,857.7 мянган төгрөгийн урамшуулал нэмэгдсэн байна.

1.1.2 Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 07 дугаар тогтоолоор 2017 оны ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг 1,341,415.7 мянган төгрөгөөр төлөвлөж, баталсан бөгөөд төсвийн тодотголоор 1,634,544.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 2,975,959.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн 2017 оны орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

ОНХС-гийн орлогын нэр	Орлогын		Зөрүү
	Төлөвлөлт	Гүйцэтгэл	
ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого	1,185,395.0	1,178,082.1	7,312.9
ОН-ийн татварын орлогоос санхүүжих	156,020.7	197,052.0	-41,031.3
ОНХС-ийн өөрийн орлого		8,771.4	-8,771.4
2016 оны дансны үлдэгдэл		793,182.9	-793,182.9
Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас		798,871.5	-798,871.5
Нийт дүн	1,341,415.7	2,975,959.9	-1,634,544.2

Хүснэгтээс харахад: ОНХНС-гаас олгох шилжүүлэг 7,312.9 мянган төгрөгөөр буурч, ОН-ийн татварын орлого 41,031.3 мянга, аймгийн баяр наадмаар авто машины зогсоолын үнэ, үйлчилгээний газруудын хураамж, бүртгэлийн хураамжаас орсон орлого 8,771.4 мянга, 2016 оны дансны үлдэгдлээс 793,182.9 мянга, төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 798,871.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр аймгийн хэмжээнд нийт дүнгээрээ 121.9%-иар нэмэгдсэн байна.

1.1.3 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийн нийт 2,975,959.9 мянган төгрөгийг дараах 5 нэр, төрлөөр бүрдүүлсэн байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого
2. Орон нутгийн татварын орлого
3. ОНХС-гийн өөрийн орлого
4. 2016 оны дансны үлдэгдэл
5. Аймаг, сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас тус тус бүрдүүлжээ.

Аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг нэр, төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

ОНХС-гийн орлогын нэр	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС	Баянтал сумын ОНХС	/мянган төгрөгөөр/
					Нийт дүн
ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого	589,915.9	386,355.0	156,561.7	45,249.5	1,178,082.1
ОН-ийн татварын орлогоос санхүүжих	197,052.0				197,052.0

ОНХС-ийн өөрийн орлого	8,771.4				8,771.4
2016 оны дансны үлдэгдэл	524,505.4	37,375.6		231,301.9	793,182.9
Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас	731,832.9	49,944.7	14,709.2	2,384.7	798,871.5
Нийт дүн	2,052,077.6	473,675.3	171,270.9	278,936.1	2,975,959.9

Хүснэгтээс харахад: Нийт эх үүсвэрийн 39.6% буюу 1,178,082.1 мянган төгрөгийг ОНХНС-гийн шилжүүлгийн орлогоос, 6.6% буюу 197,052.0 мянган төгрөгийг татварын орлогоос, 0.3% буюу 8,771.4 мянган төгрөгийг баяр наадмын үйлчилгээний орлого, 26.7% буюу 793,182.9 мянган төгрөгийг 2016 оны дансны үлдэгдлээс, 26.8% буюу 798,871.5 мянган төгрөгийг Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас тус тус бүрдүүлсэн байна.

1.1.4 Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох хуулийн заалтыг баримтласан байна.


2017 онд ОНХНС-гаас олгогдсон 1,178,082.1 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг хасч тооцон, үлдэгдлийг аймаг, сумдад итгэлцүүрийн дагуу хуваарилсан бөгөөд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Засгийн Газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.2-т заасан орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг нөлөөлөх байдлыг харгалзан хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлага болон ОУБ-ын урамшуулал болох нийт 412,101.7 мянган төгрөгийг хасч тооцон үлдэгдэл 765,980.4 мянган төгрөгийн санхүүжилтийн 30% буюу 229,794.1 мянган төгрөгийг сумдын ОНХС-д, 70% буюу 536,186.3 мянган төгрөгийг АОНХС-д тус тус хуваарилсан байна. Тухайлбал:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний суурь зардалд /100.0%/ 16,826.6 мянга,
2. “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын санхүүжилт /жилийн төсвийн 50.0%/ 116,514.4 мянга,
3. Ус хангамжийн татаас /100.0%/ 36,903.0 мянга
4. Олон улсын байгууллага буюу “Тогтвортой амжиргаа-III” төслөөс олгогдсон 241,857.7 мянган төгрөгийн урамшуулал нь сумдад нэр заагдаж төлөвлөгдсөн тул аймаг, сумдад итгэлцүүрээр хуваарилах санхүүжилтээс тус тус хасч тооцсон байна.

ОНХНС-гаас 2017 онд аймаг, сумдад олгосон орлогын шилжүүлгийг диаграммаар харуулбал:

2017 онд аймаг, сумдад хуваарилсан
ОНХС-гийн орлогын шилжүүлэг



Диаграммаас харахад: АОНХС-д 536,186.3 мянга, Сүмбэр сумын ОНХС-д 117,232.0 мянга, Шивээговь сумын ОНХС-д 67,312.6 мянга, Баянтал сумын ОНХС-д 45,249.5 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

1.1.5 ОНХНС болон аймгийн ОНХС-гаас батлагдсан орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Тус аймагт 2017 онд ОНХНС-гаас 1,185,395.0 мянган төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн боловч улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө дутуу биелсэнтэй холбоотой төсвийн тодотголоор 7,312.9 мянган төгрөгийн орлого хасагдаж, 1,178,082.1 мянган төгрөгийн шилжүүлгийн орлогыг олгохоор төсөв батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжүүлсэн байна.

2017 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарьтай тулган баталгаажуулсныг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

2017 он, улирал	Батлагдсан төсвийн хуваариар олгох шилжүүлгийн дүн	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийн дүн	Зөрүү
1	177,624.9	153,201.7	24,423.2
2	515,929.4	540,352.6	-24,423.2
3	257,380.8	175,721.9	81,658.9
4	227,147.0	308,805.9	-81,658.9
Нийт дүн	1,178,082.1	1,178,082.1	0.0

Хүснэгтээс харахад: ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгоогүй байна. Тухайлбал: 1-р улиралд 24,423.2 мянга, 3-р улиралд 81,658.9 мянган төгрөгөөр дутуу, 2-р улиралд 24,423.2 мянга, 4-р улиралд 81,658.9 мянган төгрөгөөр тус тус илүү санхүүжүүлсэн байна.

Харин 2017 онд аймгийн ОНХС-гаас сумдад олгосон орлогын шилжүүлгийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

2017 он	Төсвийн хуваариар	Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Зөрүү
Сүмбэр сумын ОНХС-д олгосон санхүүжилт			
1-р улирал	55,762.30	11,440.90	44,321.40
2-р улирал	217,649.00	261,970.40	-44,321.40
3-р улирал	82,528.90	56,149.30	26,379.60
4-р улирал	30,414.80	56,794.40	-26,379.60
Шивээговь сумын ОНХС-д олгосон санхүүжилт			
1-р улирал	11,900.80	6,505.50	5,395.30
2-р улирал	110,404.20	115,799.50	-5,395.30
3-р улирал	17,603.90	11,860.60	5,743.30
4-р улирал	16,652.80	22,396.10	-5,743.30
Баянтал сумын ОНХС-д олгосон санхүүжилт			
1-р улирал	8,207.50	4,486.60	3,720.90
2-р улирал	14,183.60	17,904.50	-3,720.90
3-р улирал	11,802.70	7,952.00	3,850.70
4-р улирал	11,055.70	14,906.40	-3,850.70

Хүснэгтээс харахад: ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүйгээс сумдад олгох орлогын шилжүүлгийг мөн батлагдсан төсвийн хуваариас илүү, дутуу санхүүжүүлсэн байна.

1.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна

1.2.1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлыг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөөгүй байна.

Аймгийн ХОХБТХ болон Сүмбэр, Шивээговь сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн нь аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлтэй хэрхэн уялдуулсан эсэх тодорхойгүй, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг тусгаж төлөвлөсөн байна.

1.2.2 Тухайн жилд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль журмын дагуу иргэдээс санал авч, урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж хэлэлцүүлсэн байна.

Аймгийн ХОХБТХ болон Сүмбэр, Шивээговь сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн нь аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг төлөвлөхдөө хууль журмын дагуу аймаг, сумдын иргэд, орон нутгийн төсвийн болон ОНӨААТҮГ-аас санал авч, урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, иргэдэд танилцуулан багийн ИНХ-аар хэлэлцүүлж саналыг эрэмбэлэн ажилласан ба эцэслэсэн жагсаалтыг аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.

Харин Баянтал сум нь тус сумын ИТХ-ын тогтоолоор 2017 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан боловч иргэд, байгууллагаас авсан саналын хуудас, урьдчилсан саналын жагсаалт, хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, эрэмбэлсэн маягтуудыг аудитын явцад ирүүлээгүй болно.

Аймгийн Засаг даргын 2016.08.09-ний өдрийн А/239 тоот захирамжаар аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг бодитой төлөвлөж, төсөл нэг бүр дээр арга зүйн зөвлөмж, дүгнэлт гарган холбогдох хууль, журмын дагуу иргэд олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн, аймгийн хөгжлийн цогц бодлоготой уялдсан хөтөлбөрийг танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосон боловч дээрх захирамжийг хэрэгжүүлж ажилласан байна.

1.2.1.3 АОНХС нь иргэдээс ирсэн саналыг хууль тогтоомжид тавьсан шаардлагын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг багийн ИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлсэн саналыг батлуулж төлөвлөгөөнд тусгуулж байгаа боловч төсвийн тодотголоор иргэдийн санал аваагүй болон эрэмбэлээгүй нийт 5 ажлыг төлөвлөгөөнд тусгуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2.1.4 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлын ТЭЗҮ, зураг төсөв бүрэн хийгдсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалтад ТЭЗҮ, зураг төсөвгүй ажил батлагдаагүй байна. Тухайлбал: аймгийн ХОХБТХ болон сумдын мэргэжилтнүүд 2017 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг өмнөх оны ОНХС-гийн төсөвт батлуулж, хийлгэсэн байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.

1.2.2.1 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль журмын дагуу үнэлээгүйгээс гомдол гарсан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт 63 төсөл, хөтөлбөрт 2,218,660.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

ОНХС-гийн нэр	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		Тоног төхөөрөмж		Их засвар		Хөтөлбөр төсөл, арга хэмжээ		Нийт дүн	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
АОНХС	11	678,064.1	7	355,231.4	8	680,099.5	2	35,000	28	1,748,395.0
Сүмбэр сумын ОНХС	7	174,000.0	1	10,000.0	2	65,000.0			10	249,000.0
Шивээговь сумын ОНХС			4	93,700.0	9	58,940.0			13	152,640.0
Баянтал сумын ОНХС	4	24,800.0	5	20,825.0			3	23,000	12	68,625.0
Нийт дүн	22	876,864.1	17	479,756.4	19	804,040.5	5	58,000.0	63	2,218,660.0

Хүснэгтээс харахад: Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажил 39.5%, тоног төхөөрөмж худалдан авах 21.6%, их засварын ажил 36.2%, хөтөлбөр, төсөл арга хэмжээ 2.7%-ийг тус тус эзэлж байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх нийт 28 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 6 ажилд НТШ, 18 ажилд харьцуулалтын, 4 ажилд ШХА-ын аргыг сонгохоор төлөвлөсөн боловч 22 ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулан 5 ажлыг НТШ, 12 ажлыг харьцуулалтын, 5 ажлыг ШХА-ын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тухайлбал: харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар төлөвлөсөн 1 ажлын тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан бол Сүмбэр суманд 6 ажлын /1 НТШ, 5 харьцуулалт хийх/ тендер шалгаруулалтын эрхийг шилжүүлсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас сонгон шалгаруулсан нийт 25 ажлаас 5 ажлын тендер оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргаж хянуулсан байна. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна дулаалга, фасадны ажлын гүйцэтгэгчээр “Их даян бүүвэй” ХХК шалгарсан боловч “Вилла бридж” ХХК-иас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2017 оны 6-1/2418 дугаартай албан бичгээр уг тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийхийг зөвлөснөөр дахин үнэлгээ хийгдэж, “Вилла бридж” ХХК гүйцэтгэгчээр шалгарсан байна.
2. Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна дулаалга, фасадны ажлын гүйцэтгэгчээр “Опен девелопмент” ХХК шалгарсан боловч “Зэт Ай И Ти” ХХК, “Морин сувд” ХХК, “Гарден сити” ХХК-иудаас гаргасан гомдолд Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2017 оны 6-1/4557 дугаартай албан бичгээр дээрх тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсны дагуу дахин үнэлгээг хийж “Цагаан зуун” ХХК-ийг шалгаруулсан бөгөөд тендер оролцогчдоос дахин гомдол гаргасан байна. Мөн дахин тендер зарлаж “Гурван дэлгэр” ХХК шалгарч гэрээ байгуулагдсан ба хугацаа алдсанаас ажлыг он дамжин хийсэн байна.

3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэрэлтүүлэг хийх ажлын гүйцэтгэгчээр “ОСО констракшн” ХХК шалгарсан боловч “Отгон зам” ХХК-иас гаргасан гомдолд Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2017 оны 6-1/3463 дугаартай албан бичгээр уг тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийх зүйтэй гэсэн хариу ирүүлсний дагуу дахин үнэлж гүйцэтгэгчээр нь “ОСО констракшн” ХХК шалгарсан байна.
4. Нийтийн эзэмшлийн авто замын дагуух гэрэлтүүлгийн толгойг шинэчлэх ажлын гүйцэтгэгчээр “Эс Жи Эм” ХХК шалгарсан боловч “Анар зоне” ХХК-иас гаргасан гомдлыг хянан Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газраас 6-1/7117 дугаартай албан бичгээр уг гомдол нь үндэслэлгүй тул тендер шалгалуурлалтыг цааш үргэлжлүүлэх тухай шийдвэр гарсан байна.
5. Зөөврийн угсардаг Лед дэлгэц, тоног төхөөрөмжийн хамт нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох ажилд 2 компани оролцоноос тендерийн шаардлага хангаагүй гэж үзэн шууд гэрээ байгуулах шийдвэр гарсан боловч тендерт оролцогчдоос гомдол гарч дахин үнэлгээ хийж уг тендерийг хүчингүй болгосон байна.

Дээрх гомдлыг шийдвэрлэсэн байдлыг харахад 5 ажлын 4 нь үндэслэлтэй гэж гарсан бөгөөд үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн хийгээгүй байна.

Тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу хийхгүй байгаа талаар жил бүр Сангийн яаманд гомдол санал гардаг зөрчил давтагдсаар байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цаашид үнэлгээний хорооны гишүүдийг арга зүйн зөвлөмжөөр хангаж, хариуцлагыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах, тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хууль, холбогдох журамд нийцүүлэн хийх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 10, аймгийн ОНХС-гаас шилжүүлсэн 6 ажлын 2-т тус тус тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан байна.

Сүмбэр сумаас ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 2 ажлыг НТШ, 7 ажлыг харьцуулалтаар, 3 ажлыг ШХА-аар хийхээр төлөвлөсөн бөгөөд 2 ажлыг НТШ, 7 ажлыг харьцуулалтын, 3 ажлыг ШХА-ын аргаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан боловч харьцуулалтын аргаар зохион байгуулсан 3 ажлын тендерийн харьцуулалт амжилтгүй болсноор шууд гэрээ байгуулсан байна.

Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын техникийн давхрын шугам сүлжээний их засварын ажлын тендер шалгаруулалтаар “Зорь бүтээ” ХХК-ийг сонгон шалгаруулсан боловч тендер оролцогч “Ус Ду” ОНӨААТҮГ-аас гаргасан гомдол Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2017 оны 6-1/4674 дугаартай албан бичгээр дахин хянаж үзэх шаардлагатай гэсэн шийдвэр ирсний дагуу тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хянаж гүйцэтгэгчээр “Ус Ду” ОНӨААТҮГ шалгарсан байна.

Шивээговь сумын ОНХС нь 5 ажлыг харьцуулалтаар, 8 ажлыг ШХА-аар хийхээр төлөвлөсөн боловч харьцуулалтын аргаар гүйцэтгэгч сонгон шалгаруулах 5 ажлын 1 нь амжилтгүй болсноор шууд гэрээ байгуулж, 5 ажлыг ШХА аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 3 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Баянтал сумын ОНХС нь 13 ажлыг ШХА-ын аргаар хийхээр төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

1.2.2.2 Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон байна.

2017 онд АОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 10 ажлын хяналтын зардалд 15,738.4 мянга, Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 7 ажлын хяналтын зардалд 10,567.9 мянга, Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 4 ажлын хяналтын зардалд 2,252.7 мянга, Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 3 ажлын хяналтын зардалд 3,245.6 мянга, нийт 24 ажлын хяналтын зардалд 31,804.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр гэрээнд тусгагданы дагуу захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-аар хийлгэсэн байна. Зарим ажил бүрэн хийгдээгүйтэй холбоотойгоор нийт 6,175.3 мянган төгрөгийн хяналтын зардал бүрэн олгогдоогүй байна.

1.2.2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүнгүй байна.

2017 онд аймаг сумдын ОНХС-гаар нийт 2,975,959.9 мянган төгрөгийн 108 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 2,300,151.2 мянган төгрөгийг зарцуулж, 675,808.7 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

Нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
Аймгийн ОНХС	2,052,077.6	1,464,469.3	587,608.3
Сүмбэр сумын ОНХС	473,675.3	420,607.1	53,068.2
Шивээговь сумын ОНХС	171,270.9	160,496.0	10,774.9
Баянтал сумын ОНХС	278,936.1	254,578.8	24,357.3
Нийт дүн	2,975,959.9	2,300,151.2	675,808.7

Хүснэгтээс харахад: 2017 онд хийгдэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д 587,608.3 мянга, Сүмбэр сумын ОНХС-д 53,068.2 мянга, Шивээговь сумын ОНХС-д 10,774.9 мянга, Баянтал сумын ОНХС-д 24,357.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн дансны үлдэгдлийг дэлгэрэнгүй байдлаар ангилан хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Нэр	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС	Баянтал сумын ОНХС	ДҮН
2016 оны он дамжсан ажлын санхүүжилт	16,407.4	8,921.2		9,500.0	34,828.6
2017 оны дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилт	546,800.0	28,868.8	10,774.9	9,588.3	596,032.0
Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэмнэлт	23,833.0			2,069.0	25,902.0
2017 оны ажлын гэрээний хэмнэлт	567.9	15,278.2		3,200.0	19,046.1
Нийт дүн	587,608.3	53,068.2	10,774.9	24,357.3	675,808.7

Хүснэгтээс харахад: 2016 оны он дамжсан ажлын санхүүжилт 5.1%, 2017 онд хэрэгжээгүй буюу дутуу хийгдсэн ажлын санхүүжилт 88.2%, ажлын гэрээний болон хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэмнэлт 6.7%-ийг тус тус эзэлж байна. Энэ нь төсвийн тодотголоор нэмэгдүүлсэн ажлын санхүүжилт болон дутуу хийгдсэн ажлын санхүүжилт дийлэнх хувийг эзэлж байна.

Аймаг, сумдын 2017 оны ОНХС-ийн зарцуулалтаар аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийг дурдвал:

Аймгийн ОНХС-гийн зарцуулалт:

1. Өмнөх оны ажил 5 дугаар сургуулийн гадна тохижилтын 116,588.8 мянган төгрөгийн ажлыг “Илчит сансар” ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн боловч хогийн сав болон тоглоомыг дутуу суулгаснаас салж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2. Аймгийн төвийн гудамж, теле камерийн системд холбох 217,343.0 мянган төгрөгийн ажлыг “Би Си Ти” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч 6 камер нь ажиллахгүй, ашиглалтын шаардлага хангаагүй
3. Нийтийн зэээмшлийн гудамж тоглоомын талбайн тохижилтын 75,846.3 мянган төгрөгийн ажлыг “Өгөөмөрийн шанд” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч сагсны торон хашаа эвдэрсэн, гэрэлтүүлгийн толгой хагарсан
4. 5-р сургуулийн дотуур байрны чийрэгжүүлэлтийн танхимд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 15,000.0 мянган төгрөгийн ажлыг “Шилийн Их баян” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч гүйлтийн зам нь хүчин чадлаас доогуур нийлүүлэгдсэн, дасгалын гудас нь чанаргүй хээ нь арилсан
5. Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн журмыг зөрчиж байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж, аймгийн ЗДТГ-ын уулзалтын өрөөний тохижилтын ажлыг хийж гүйцэтгүүлсэн зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд гүйцэтгэгч байгууллагуудаар хөрөнгийг дахин засварлуулах болон хөрөнгийг сольж шаардлага хангасан хөрөнгө нийлүүлэх талаар зөрчлийг арилгуулах албан шаардлага, хууль тогтоомж зөрчиж урсгал үйл ажиллагааг санхүүжүүлсэн аймгийн ЗДТГ-ын болон ХОХБТХ-ийн дарга нарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Баянтал сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. Баянтал суманд Интернет тавих 5,000.0 мянган төгрөгийн ажлыг “Их зэст хөгжил” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч туршилтын хугацаанд интернетийг ашиглаж, сарын төлбөр 385.0 мянган төгрөгийг сумын төвийн байгууллагууд төлөх төсөвгүйгээс зориулалтын дагуу ашиглаагүй
2. Сумын Соёлын төвд цэвэр бохир усны шугамд холбох 7,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээ байгуулж “Чадварлаг залуус” бүлгээр гүйцэтгүүлсэн боловч ариун цэврийн өрөөнөөс нь бохир үнэртэж, хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон
3. Баянтал сумын Өргөх станцын зураг төсөв боловсруулах 10,000.0 мянган төгрөгийн ажлыг “Кингсийн энд Инженер” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаа дууссан байхад ажлыг хүлээн аваагүй, үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, гэрээний үүргээ биелүүлээгүй
4. Баянтал сумын 2-р багийн зураг төсөв боловсруулах 8,000.0 мянган төгрөгийн ажлыг “Сталь-3003” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч боловч гэрээний хугацаа дууссан байхад ажлыг хүлээн аваагүй, үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, гэрээний үүргээ биелүүлээгүй
5. Баянтал сумын 4-р сургуулийн дотуур байрны засварын 54,896.0 мянган төгрөгийн ажлыг “Харвайн толгой” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч байрны дотор өрөөнүүдийн хаалганы амлагааг чанаргүй хийж гүйцэтгэсэнээс эвдэрсэн
6. Сумын 152 дугаар байрны өмнөх тоглоомын талбайн тохижуулах 125,386.4 мянган төгрөгийн ажлыг “Койот трейд” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч суурилуулсан тоглоом нь унаж эвдэрсэн, сагсны талбайн хаалга салсан зэргээс чанаргүй, үр дүнгүй ажлууд хийгдсэн зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, дахь заалтуудыг зөрчсөн байна

Иймд чанаргүй хийгдсэн болон эвдэрсэн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагуудаар дахин засварлуулж хэвийн болгох, зориулалтын дагуу ашиглах боломж нөхцлөөр хангуулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Сүмбэр сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. Аймгийн төвийн хогийн цэгийг хашаажуулах 48,116.3 мянган төгрөгийн ажлыг “Суварган говь” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч хогны хашаанууд эвдэрч, нурсан
2. Сумын төвийн усан сан засварлах шинээр барих 40,000.0 мянган төгрөгийн ажлыг “Энхжих формат” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч усан

сангийн цонхны хамгаалалтыг хийгээгүйгээс цонх нь хагарсан, дээврийн төмөр нь салхинд хууларсан, төв худгийн дотор засвар, гадна өнгөлгөө нь хууларсан

- 3-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцны саравчны бэхэлгээ, орцны гадна талд хогийн сав, сандал хийх 28,000.0 мянган төгрөгийн ажлыг “Их зэст хөгжил” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч гэрээний хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй, суулгасан сандал бэхэлгээ дутуу хийсэн, гэрээний хугацаанд бүрэн хийгдээгүй ажилд алданги тооцоогүй зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд чанаргүй хийгдсэн болон эвдэрсэн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагуудаар дахин засварлуулж хэвийн болгох, ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шивээговь сумын ОНХС-гийн зарцуулалт:

1. Сумын төвийг камержуулах 15,000.0 мянган төгрөгийн ажлыг “Чойрын долгион” ХХК-тай гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн боловч камерийг муу суурилуулснаас салхитай өдөр ажилладаггүй, нийт 8 камераас 2 камер нь ажиллахгүй болсон
2. 3-р Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах 7,000.0 мянган төгрөгийг ажлыг “Альпнстрейд” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч 4 ширэмтэй пийшингийн тень шатсанаас 2 ширэм нь ажиллахгүй болсон зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд чанаргүй хийгдсэн болон эвдэрсэн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагуудаар дахин засварлуулж, ашиглалтанд оруулж, зориулалтын дагуу бүрэн ашиглах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Түүнчлэн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 2013 оноос хойш он дамжсан зарим ажлуудыг одоог хүртэл бүрэн гүйцэтгүүлээгүйгээс ажлыг хүлээн аваагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, тайлан тэнцэлд тусгагдсан авлага, өглөг өнөөдрийг хүртэл барагдаагүй хэвээр байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-гаас хоршоологчдын байрны санхүүжилтийн үлдэгдэл 5,700.0 мянга, 2013 онд хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний төв зогсоол байгуулах ажлын гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “Магнус солус” ХХК шалгарч, 58,070.2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэн гэрээний дагуу 2013 онд 47,362.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй, хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой акт үйлдэн ажлыг зогсоож, 2014.04.10-наас 2014.05.20-ныг хүртэлх хугацаанд ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээг сунгасан байна. Гэтэл 2014 онд уг компани ажлаа хийж гүйцэтгээгүй, холбоо барих боломжгүй, хаяг тодорхойгүй, эзэн холбогдогч нь олдохгүй байгаа гэсэн

шалтгаанаар урьдчилж олгосон санхүүжилт 47,362.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар, санхүүжилтийн үлдэгдэл 16,407.4 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж одоог хүртэл барагдуулаагүй байна. Иймд холбогдох хууль журмын дагуу тус компанитай байгуулсан гэрээний биелэлтийг тооцож, авлага, өглөгийг барагдуулах тухай зөвлөмжийг СТА-аар өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, тодорхой арга хэмжээ аваагүй байна.

- Сүмбэр сумын ОНХС-аас сумын төв замын дагуу мод тарьж, хашаа барих нийт 93,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр “Классик Тохижилт” ХХК шалгарч, урьдчилгаа санхүүжилт 28,087.4 мянган төгрөг олгосон бөгөөд ажлын гүйцэтгэлийг хянах явцад хашаа нь техникийн нөхцлийн дагуу хийгдээгүй тул гэрээг цуцалж, шүүхэд шилжүүлэн, олгосон санхүүжилтийг авлагаар бүртгэсэн, мөн Хонхор хотхоны 1 болон 15-р байрны дундах тогтлоомын талбайг сэргээн засварлах ажлыг дутуу гүйцэтгэж, гэрээний биелэлтийг дүгнээгүй, ажлыг хүлээлгэн өгөөгүйгээс санхүүжилтийн үлдэгдэл 8,921.2 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн байна. Мөн авлага, өглөгийг барагдуулах тухай зөвлөмжийг СТА-аар өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Дээрх зөрчил, дутагдлууд нь захиалагч ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа санхүүжилтийн ихэнх хувийг /50.0%-70.0%/ олгохоор тусгасан, чанаргүй хийгдсэн ажлуудыг улсын комисс хүлээн авсан, ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй хийгдсэн, гэрээний биелэлтийг дүгнээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага болон алданги тооцоогүй, төсвийн хөрөнгийг ашиглах боломжгүй, үр өгөөжгүй хөрөнгө оруулалтад зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд авлага, өглөгийг барагдуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

1.2.2.4 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2017.12.27-ны 59 дүгээр тогтоолоор аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгосон байна.

Тус тогтоолд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгуулах жагсаалтад мөнгөн дүнг зөрүүтэй тусгасан болон зарим ажлыг орхигдуулсан байна. Үүнд:

1. Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 4-р сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл нийлүүлэх ажлын 3,725.0 мянга, 4-р цэцэрлэгийн 100 хүүхдийн зөөлөн эдлэлийн 2,500.0 мянга, сумын өвс, тэжээлийн 5,000.0 мянга, 152-р байрны өмнөх тоглоомын талбайн тохижилт авто зогсоолын ажлын 129,385.9 мянга, нийт 140,610.9 мянган төгрөгийн

хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгах талаар шийдвэр гараагүй, орхигдуулсан

2. Сүмбэр сумын ОНХС-гаар хийгдсэн Сүмбэр сумын 2-р багийн айл өрхийг хог хаягдлаа ангилан ялгах хогийн саваар хангах ажлыг 1,268.5 мянга, айл өрх, гудамж талбайн хаягжуулалтын ажлыг 4,542.0 мянга, аймгийн төвийн хогийн цэгийг хашаажуулах ажлыг 6,276.0 мянга, Баянтал сумын 4-р сургуулийн дотуур байрны засвар 5,033.1 мянга, нийт 17,119.6 мянган төгрөгөөр тус тус дутуу тусгасан байна.

Мөн дээрх тогтоолд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгуулах жагсаалтаар батлагдсан боловч данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-гаас хийгдсэн Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна дулаалга, фасадны ажил 184,585.0 мянга, Нэгдсэн эмнэлэгийн их засварын ажлын 79,972.4 мянга, Сансар цэцэрлэгийн фасадны ажлын 10,000.0 мянга, 5 дугаар сургуулийн дотуур байрны гадна тохижилтын ажлын 116,588.8 мянга, 5-р сургуулийн дотуур байрны чийрэгжүүлэлтийн танхимд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын 14,807.5 мянга, “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-ын үүрдэг хогийн савны 12,125.0 мянга, АЗДТГ-ын уулзалтын өрөө, хурлын заалны тохижилтын ажлын 9,967.9 мянга, нийт 428,046.6 мянга,
2. Баянтал сумын ОНХС нь 4-р сургуулийн монтаж тавих ажлын 8,800.0 мянга, сумын Соёлын төвийг цэвэр бохир усны шугамд холбох ажлын 7,000.0 мянга, 4-р сургуулийн дотуур байрны засварын ажлын 54,896.0 мянга, 4-р цэцэрлэгийн 100 хүүхдийн зөөлөн эдлэлийн 2,500.0 мянга, сумын өвс, тэжээлийн 5,000.0 мянга, 152-р байрны өмнөх тоглоомын талбайн тохижилт, авто зогсоолын ажлын 129,385.9 мянга, 4-р цэцэрлэгийн бүлгийн тоглоом нийлүүлэх ажлын 5,000.0 мянга, нийт 212,581.9 мянга,
3. Сүмбэр сумын ОНХС нь Айл өрхийн гудамж талбайн хаягжуулалтын ажил 70,754.8 мянган төгрөгийн ажлыг тус тус бүртгэл тайланд тусгаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд хөрөнгийн бүртгэлийг нэр, төрлөөр болон дансны ангиллаар үнэн, зөв бүртгэх талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын дагуу үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй байна.

1.3.1 ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд тавих хяналт хангалтгүй байна.

1.3.1.1 ОН-ийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн ИТХ-аас АИТХТ-ийн 2017.07.25-ны 28 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийх үүрэг бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан байна.

Тус ажлын хэсэг ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажлын тайланг АИТХТ-дийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд аймгийн ХОХБТХ-т ажил сайжруулах болон цаашид анхаарч ажиллах талаар дараах үүрэг, чиглэлийг өгсөн байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын ажлын тендер зарлахдаа ажлын онцлогоос хамаарч техникийн тодорхойлолт хийдэггүй, ерөнхий байдлаар 1 загвараар хийдэг
2. Ажил хүлээн авахдаа ажлын гэрээ, техникийн тодорхойлолтын дагуу тулган хүлээн авдаггүй, ажлын гүйцэтгэлд хяналтаа бүрэн тавьдаггүй, материалыг лабораторийн шинжилгээнд бүрэн оруулдаггүй, материалын гарал үүсэл нь тодорхой бус
3. Ашиглагч байгууллагын саналыг тендерийн баримт бичигт тусгадаггүй, ажил хүлээн авахаас өмнө урьдчилан танилцуулдаггүйгээс чанаргүй ажлууд хүлээн авдаг, тухайн ажилтай холбоотой урсгал зардлаа төлөвлөөгүйгээс өр, авлага үүсдэг, улсын комисст орж ажиллаж буй гишүүд уг ажлын гүйцэтгэлийн талаар тодорхой мэдээлэлгүй хүлээн авдаг.
4. Аймгийн Засаг даргын дэргэд орон тооны бус инженерийн холбоог байгуулах

Тус ажлын хэсгээс өгсөн дээрх чиглэлд хугацаа тодорхойгүй, мөн аймгийн ХОХБТХ-т албан ёсоор хүргүүлээгүйгээс уг чиглэлийн дагуу хариу арга хэмжээ авч ажилласан талаарх ажлын тайлан, гүйцэтгэлийг гаргаагүй, ажлын хэсэгт тайлагнаагүй байна.

Сүмбэр суманд ИТХ-ын дэргэдэх төсөв санхүү, дэд бүтэц-үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан хороодын дарга, гишүүд 2017 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаа, ажлын явцтай танилцсан танилцуулгыг ирүүлсэн бөгөөд хяналт тавьж ажилласан болон зөвлөмж санал хүргүүлсэн талаар тодорхойгүй байна.

Шивээговь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор ажил тус бүрээр хяналтын бүлэг томилсон боловч хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй бөгөөд зөвхөн ажлын явцын танилцуулгыг ирүүлсэн байна.

Баянтал сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь 2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний биелэлтэнд иргэдтэй хамтарч хийсэн хяналтын хорооны тайланг ирүүлсэн бөгөөд тус хяналтаар сургуулийн дотуур байрны засвар, соёлын төвийн цэвэр бохир усны холболт, сурагчийн ширээ сандал нийлүүлэх болон ЭМТ-ын тоног төхөөрөмж, сургуулийн спорт заалны цахилгааны монтаж, цэцэрлэгийн бүлгийн тоглоом зэрэг

ажлууд нь хяналтын явцад ямар нэгэн зөрчил дутагдалгүй чанартай хийгдсэн бол 152-р байрны дундах тоглоомын талбай, авто зогсоолын ажил, 4-р цэцэрлэгийн болон сургуулийн дотуур байрны хүүхдийн зөөлөн эдлэл нийлүүлэх ажилд илэрсэн зөрчил дутагдлыг залруулсан байна.

1.3.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээнд дотоод аудитын албанаас явцын хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-гийн 2017 оны хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний явц болон гүйцэтгэлд дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд ОНХС-ийн зарцуулалт болон ажлын явц, гүйцэтгэлд хяналт шалгалт хийж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3.2.1 Аймаг, сумд ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилласан байна.

Сумдын ОНХС болон хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг сар бүр аймгийн ХОХБТХ-т хүргүүлж, аймгийн ХОХБТХ-ээс аймгийн хэмжээний тайланг нэгтгэн Сангийн яаманд 2 удаа хүргүүлж ажилласан байна.

1.3.2.2 Аймгийн Засаг дарга ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилт, тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулаагүйгээс дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн заавар”-ын 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн заавар”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3.2.3 Аймаг, сумдын ОНХС-гийн Шилэн дансны цахим хуудсан мэдээлсэн мэдээллийн 33% нь хугацаа хоцорсон мэдээлэл байна.

2017 онд аймаг болон сумдын ОНХС-гийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахимхуудсанд мэдээлсэн байдлыг дараахь 8 үзүүлэлтээр шалгалаа. Үүнд:

1. ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэл
2. Засгийн газрын болон ОНТС-гийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл

3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл
5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл
6. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг
7. Худалдан авах ажиллагааны тайлан
8. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн

Шилэн дансны нэгдсэн цахимхуудсанд аймаг, сумдын хэмжээнд ОНХС-гийн нийт 284 мэдээлэл байршуулахаас бүрэн байршуулсан бөгөөд үүнээс 94 мэдээллийн хугацаа хоцорсон төлөвтэй байна. Тухайлбал: аймгийн ОНХС 20, Сүмбэр сумын ОНХС 29, Баянтал сумын ОНХС 33, Шивээговь сумын ОНХС 12 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Бүлэг 2

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй, түүнд тавих хяналтыг дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.1 Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулалт, зээлийн гэрээний биелэлт, хөрөнгийн эх үүсвэрийг журамд заасны дагуу төлөвлөөгүй, зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг хугацаанд нь төвлөрүүлэх ажил хангалтгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу сумдын жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх зээл ашиглалт, зээлийн хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан төлөвлөж, Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.12-т зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор сум хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилсан байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/38 дугаар тушаалаар тус аймагт сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг баталж, Сүмбэр суманд 265,000.0 мянга, Шивээговь суманд 50,000.0 мянга, Баянтал суманд 50,000.0 мянга, нийт 365,000.0 мянган төгрөг хуваарилсан байна.

Сум хөгжүүлэх санд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2013 оноос хойш дахин хөрөнгө хуваарилаагүй бөгөөд сангийн орлогын эх үүсвэрийг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 2.1.3, 2.1.4-д

зааснаар зээлийн эргэн төлөлт, хүү, алдангийн орлогоос бүрдүүлж, зээлийг олгож ирсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 2017 онд Сум хөгжүүлэх сангийн орлогын эх үүсвэрийг нийт 1,035,785.7 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр 100,892.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөний биелэлт 9.7 хувьтай байна.

Сумдын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/ Хувь
1	Сүмбэр	979,868,000.0	74,264,591	7.6%
2	Шивээговь	36,000,000.0	16,087,784	44.7%
3	Баянтал	19,917,700.0	10,540,500.0	52.9%
	Дүн	1,035,785,700.0	100,892,875.0	9.7%

Хүснэгтээс харахад: 2017 оны Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээрээ 9.7%-ийн биелэлттэй гарсан бөгөөд Сүмбэр сум 7.6%, Шивээговь сум 44.7%, Баянтал сум 52.9%-иар тус тус биелүүлсэн байна. Энэ нь зээлийн эргэн төлөлт хангалтгүй, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт муу байгааг харуулж байна.

2017 онд СХС-д улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй байна. Зээлийн гэрээний дагуу 2017 онд зээлийн үндсэн төлбөр 629,470.2 мянга, хүү 19,774.3 мянга, алданги 30,118.5 мянга, нийт 679,363.0 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхээр байгаа боловч орлогыг зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн орлогын дүнгээр нь 1,035,785.7 мянган төгрөгөөр төлөвлөж батлуулсан ба алдангийн орлогыг огт төлөвлөөгүй байна.

2017 онд нийт 100,892.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс үндсэн зээл 95,544.0 мянга, зээлийн хүү 5,051.9 мянга, алданги 297.0 мянган төгрөг байна. Зээлийн гэрээний дагуу алдангийг тухай бүр тооцдоггүйгээс алдангийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2017.12.31-ний байдлаарх зээлийн үлдэгдлийг чанарын ангиллаар нь харуулвал:

Зээлийн ангилал	Сүмбэр		Шивээговь		Баянтал		Аймгийн хэмжээнд	
	Зээлийн дүн /төгрөгөөр/	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн дүн /төгрөгөөр/	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн дүн /төгрөгөөр/	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн дүн /төгрөгөөр/	Нийт зээлд эзлэх хувь
Хэвийн	16,859,071.0	2.7%	30,364,130.0	19.2%	21,738,363.0	14.1%	68,961,564.0	7.3%
Хугацаа хэтэрсэн	37,085,000.0	5.9%	39,046,423.0	24.7%		0.0%	76,131,423.0	8.1%
Хэвийн бус	14,934,939.0	2.4%		0.0%		0.0%	14,934,939.0	1.6%
Эргэлзээтэй	4,731,501.0	0.8%	22,187,268.0	14.0%	14,000,000.0	9.1%	40,918,769.0	4.3%
Муу	558,911,955.5	88.4%	66,691,509.0	42.1%	118,713,045.0	76.9%	744,316,509.5	78.7%
Нийт зээлийн үлдэгдэл	632,522,466.5		158,289,330.0		154,451,408.0		945,263,204.5	100.0%
Нийт зээлдэгчийн тоо	87		52		37		176	

Хүснэгтээс харахад нийт 945,263.2 мянган төгрөгийн зээлийн 84.6% нь чанаргүй зээлийн ангилалд багтаж байгаа нь зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого төвлөрүүлэлт хангалтгүй, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу бүрэн төвлөрүүлж чадаагүй нь харагдаж байна.

Энэ нь Сум хөгжүүлэх сангийн зээл хариуцсан мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажилладаггүй, зээл, зээлийн хүүгийн хяналтын хуудсыг зээлдэгч тус бүр дээр хөтөлдөггүй, ажлыг хүлээлцэхдээ зээлдэгчийн хувийн хэрэг болон үндсэн зээл болон хүүгийн авлагыг хүн тус бүрээр тулгаж баталгаажуулан хүлээлцдэггүй зэргээс шалтгаалж зээлийн гэрээний дагуу үндсэн зээл, зээлийн хүү, алдангийг үнэн зөв тооцож, бүрэн төвлөрүүлж чадахгүй байна.

Тухайлбал: Сүмбэр сумын 1 зээлдэгчийн 1,155.4 мянга, Шивээговь сумын 8 зээлдэгчийн 1,994.1 мянга, Баянтал сумын 4 зээлдэгчийн 430.6 мянга, нийт 13 зээлдэгчийн 3,580.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг дутуу тооцож, зээлийг хаасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзэх/

Энэ нь Монгол Улсын НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 4 дүгээр зүйлийн 4.7, 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд дутуу төлөлттэй 13 зээлдэгчийн 3,580.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдлийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, журмын дагуу орлогын бүрдүүлэлтийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Нийт зээлийн үлдэгдлийн 84.6%-ийг чанаргүй зээл эзэлж байгаа нь сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүйг харуулж байна.

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.3 т заасан иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг Сүмбэр суманд 7, Шивээговь суманд 6, Баянтал суманд 6, нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд 2017 онд төсөл сонгон шалгаруулалт хийгдээгүй, зээл олгогдоогүй байна.

2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Сүмбэр сумын ИТХ-ын 31 тоот тогтоолоор хүүгийн орлогоос 3,609.5 мянган төгрөгийг СХС-ийн үйл ажиллагаанд зарцуулахаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр нийт 1,773.0 мянган төгрөгийг зарцуулснаас 1,040.0 мянган төгрөгийг сургалтанд, 400.0 мянган төгрөгийг шатахуунд, 333.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд тус тус зарцуулжээ.

Шивээговь болон Баянтал суманд хүүгийн орлогоос зарцуулсан зардал байхгүй байна.

Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгаар төсөл сонгон шалгаруулах комисс шударга ажилладаггүй, зээлийг он дамжуулан мөнгийг хувааж олгодог, зээлийн хэмжээг төсөлтэй уялдуулан олгодоггүй, бага олгодог зэрэг санал хүсэлтийг ирүүлсэн байна. /Хавсралт №2/

Иймд цаашид зээл олгох комисс журмын дагуу шаардлага хангасан төслийг сонгон шалгаруулж ажиллах шаардлагатай байна.

2011-2016 онуудад СХС-аас зээл авсан зээлдэгчдийн хувийн хэргийг тулган баталгаажуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Сумын нэр	Зээлдэгчийн тоо	Зээлийн гэрээтэй	Барьцааны гэрээтэй	Огт гэрээгүй
Сүмбэр	93	93	78	0
Шивээговь	52	52	38	0
Баянтал	48	44	8	3
Нийт	193	189	124	3

Дээрх хүснэгтээс харахад зээлдэгчийн зээлийн хувийн хэргийг журмын дагуу бүрэн бүрдүүлээгүй, барьцааны гэрээ байгуулдаггүй, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг гарын үсгээр баталгаажуулаагүй, хувийн хэрэгт хавсаргаагүй зөрчил илэрлээ.

Баянтал сумын 3 зээлдэгчийн 19,000.0 мянган төгрөгийн зээлийн гэрээ эх хувиараа байхгүй, гэрээ байгуулсан эсэх нь тодорхойгүй байна. Үүнд:

/төгрөгөөр/

Д.Д	Овог нэр	Регистр	Олгосон зээлийн хэмжээ	Олгосон хугацаа	Дуусах хугацаа
1.	Н.Баярсайхан	ЧГ80040210	5,000,000	2015.03.12	2018.03.12
2.	Ч.Энхболд	ЕЙ67032014	10,000,000	2015.03.12	2018.03.12
3.	Д.Ариунаа	ЗВ69041103	4,000,000	2015.03.12	2018.03.12
	Дүн		19,000,000		

Энэ нь Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.8.6, 4.8.8, Архивын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад СХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт хийж зээлдэгч нартай уулзахад ихэнх зээлдэгч нь зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байна. Мөн зээлийн үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдаагүй 176 зээлдэгчийн хувийн хэргийг эмх замбараагүй үдэж архивласан байсныг хүн тус бүрээр хувийн хэрэг үүсгүүлж цэгцлүүллээ.

Иймд журмын дагуу зээлдэгчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангах, эмх цэгцтэй, хадгалах, зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч тус бүрийн хувийн хэрэгт зээл, зээлийн хүүгийн төлбөрийн хяналтын карттай болох, сар бүрийн эцэст нягтлан бодогчтой тооцоо нийлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.3 СХС-ийн Орон тооны бус зөвлөл журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлд “зөвлөл нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавих, сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг сумын Засаг дарга хариуцан арилгах” гэж заажээ. Бодит байдал дээр сумдын Засаг дарга нар болон сан хариуцсан мэргэжилтнүүд хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийг төлүүлэх талаар зээлдэгчдэд мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласанаас өөр дорвитой ажил хийгээгүй байна.

Сумдын СХС-гийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр батлуулсан төлөвлөгөө байхгүй бөгөөд 2017 оны байдлаар СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгдээгүй, мөн тус сангийн үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлж, ИТХ-аар хэлэлцүүлсэн тайлан байхгүй байна.

СХС-ийн Орон тооны бус зөвлөл нь зээлдэгчийн судалгааг бүрэн хийгээгүй, зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллаагүй, зээлдэгчийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулдаггүй зэргээс шалтгаалан чанаргүй зээл нэмэгдсэн байна.

Энэ нь Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.2.1, 3.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд зээлийн болон зээлдэгчийн мэдээллийн санг бүрэн бүрдүүлж, Монгол банкны мэдээллийн санд оруулах, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг гаргаж хэвших зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд зээлийн үндсэн төлбөр, хүүгийн орлого, алданги, авлагыг дараахь байдлаар бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

1. Сүмбэр сумын СХС-гийн санхүүгийн тайланд авлага 878,633.7 мянга, үндсэн зээлийн төлбөрт 70,780.3 мянга, хүүгийн орлого 287.3 мянга, алданги 297.1 мянга нийт 74,364.6 мянган орлого төвлөрсөн боловч 100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
2. Шивээговь сумын СХС-гийн санхүүгийн тайланд авлага 170,226.4 мянга, үндсэн зээл 14,593.2 мянга, хүүгийн орлого 1,494.6 мянга
3. Баянтал сумын СХС-гийн санхүүгийн тайланд авлага 164,263.3 мянга, үндсэн зээл 10,270.5 мянга, хүүгийн орлого 270.0 мянган төгрөгийг тус тус бүртгэж тайлагнасан байна.

Сумдын СХС-гийн мэргэжилтнүүд зээлдэгчийн хувийн хэрэгт хяналтын карт огт ашиглаагүй, нягтлан бодогчтой алданги, зээлийн хүү, үндсэн зээлийн үлдэгдлийг сар бүр тооцоо нийлж тулган баталгаажуулаагүйгээс санхүүгийн

тайлан дахь үндсэн зээл болон хүүгийн авлага үнэн зөв, бодитой илэрхийлэгдэхгүй байна.

2017 оны байдлаар зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа барагдуулаагүйгээс үүссэн нийт 116 зээлдэгчийн 800,170.2 мянган төгрөгийн чанаргүй зээл байгаагаас 38 зээлдэгчийн 247,091.6 мянган төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлсэн байна.

2017 оны чанаргүй зээлийн үлдэгдлийг сумдаар ангилан хүснэгтээр харуулвал:

Үзүүлэлт	Сүмбэр	Шивээговь	Баянтал	Нийт
Чанаргүй зээлийн үлдэгдэл	578,578,395.5	88,878,777.0	132,713,045.0	800,170,217.5
Шүүхэд хандсан үндсэн зээлийн үлдэгдэл	182,500,887.0	6,784,157.0	57,806,551.0	247,091,595.0
Чанаргүй зээлд эзлэх хувь	32.0%	8.0%	44.0%	31.0%

Хүснэгтээс харахад: Нийт чанаргүй зээлийн үлдэгдлийн 31.0%-ийг шүүхэд шилжүүлсэн нь хангалтгүй байна.

Аудитын явцад СХС-аас зээл авсан 21 зээлдэгчийг түүвэрлэн авч уулзаж ярилцан холбогдох тайлбарыг гаргуулсан бөгөөд авсан зээлийнхээ үндсэн төлбөр, хүүгийн үлдэгдлээ тодорхой мэдэхгүй, санхүүгийн сахилга бат муутай, гэрээгээр хүлээсэн эрх үүргээ ухамсарлахгүй байсан ба зарим төрийн албан хаагчид зээл авсан боловч зээлээ хугацаанд нь төлөөгүй, ихэнх нь чанаргүй зээлийн ангилалд багтсан байна.

Эдгээр нь Засгийн Газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2, 5.3.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид сумдын СХС-ийн үйл ажиллагааг сайжруулах, чанаргүй зээлийг төлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхээс гадна СХС-ийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, зээлийн мэдээллийн санг Монгол банкны мэдээллийн сантай холбох асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Иймд чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй зээлийг төлүүлэх төлөвлөгөө боловсруулах, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.4 СХС-ийн журамд зээл болон барьцааны гэрээ, хүү төлбөрийн хуваарь, хяналтын хуудас, тайлан гаргах загвар зэргийг баталж мөрдүүлэх, мөн хариуцлагын талаар тодорхой тусгах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 84.6% нь чанаргүй зээлийн ангилалд багтаж байгаа бөгөөд энэ нь СХС-ийн үйл ажиллагаа холбогдох журамд тусгагдсан зорилго, зорилтдоо хүрээгүйг харуулж байна.

СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйл, заалт байхгүй боловч уг журамд зээл, зээлийн гэрээ болон зээлийн хүүгийн төлбөрийн хуваарь, хяналтын хуудас, тайлан гаргах загвар зэргийг нэг загвараар хавсралт байдлаар баталж, мөрдүүлэх, мөн СХС-ийн төсөл шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлийн эргэн төлөлтөд СХС хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллах, зээл олгосон эрх бүхий албан тушаалтнуудад хамаарах хариуцлагын тогтолцоог тодорхой тусгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн зээлийн мэдээллийн санг оновчтой бүрдүүлэх, программ хангамж ашиглан боловсронгуй болгох, Монгол банкны мэдээлийн санд зээлийн мэдээллийг оруулах, тус сангаас лавлагаа авах зэрэг хялбарчилсан зохицуулалт хийх шаардлагатай байна.

Банкны жишгийн дагуу зээлийн эрсдэлийн сан байгуулж, зээлийн чанарын ангиллыг сар бүр хийж хэвших нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлээс хамгаалах талтай юм.

СХС-ын журамд зээлийн үлдэгдэлтэй харилцагчид зээл олгохгүй байх зохицуулалт тусгагдаагүй, мөн банкны жишгээр шалгуур тогтоож, тооцоо судалгаа хийлгүй зээл олгож байгаа, сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүд тогтвор сууршилтай ажиллдаггүй, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл авдаггүйгээс зээлийн эргэн төлөлтөд сэтгэл гаргаж ажиллахгүй байх хандлага харагдаж байгаа бөгөөд энэ нь чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх үндэс суурь болсон байна.

Иймд сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүдэд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл болон урамшуулал олгох, уг сангийн журамд тусгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү

Бүлэг 3

Өмнөх онд хийгдсэн аудитаар ОНХС болон СХС-д өгсөн зөвлөмж, актын хэрэгжилт хангалтгүй байна.

3.1. Өмнөх оны аудитаар аймгийн ОНХС-д өгөгдсөн зөвлөмж 47.0%, акт, албан шаардлагын биелэлт 67.7%-тай байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн Нийцлийн аудитаар нийт 17 зөвлөмж өгснөөс 8 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, хариу ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн биелэлт 47.0%-тай байна.

Энэ нь Аймгийн ИТХ болон аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийгдсэн Нийцлийн аудитаар нийт 1,898.676.4 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн бөгөөд 15,210.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосноос 2 актын 5,710.0 мянган төгрөгийг барагдуулснаар төлбөрийн актын биелэлт 37.5%, нийт 536,218.5 мянган төгрөгийн 16 албан шаардлага өгснөөс 526,218.5 мянган төгрөгийн 15 албан шаардлагыг хэрэгжүүлснээр 98%-ийн биелэлттэй байна.

3.2 Өмнөх аудитаар СХС-гуудад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд 2016, 2017 онуудад санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн бөгөөд аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлыг бүрэн шийдвэрлүүлж, хугацаа хэтэрсэн зээлийг бүрэн төлүүлэх
2. Орлогын төлөвлөгөөг биелүүлж, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн, хүү, алдангийг тооцож бүрэн төлүүлэх, зээлийн эргэн төлөлтөнд анхаарч байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллах
3. Зээлийн хүү болон алдангийг нөхөн тооцож, зээлдэгч бүртэй тооцоо нийлж баталгаажуулах, зээлийн хүү болон алдангийн орлогыг авлага, орлогоор санхүүгийн тайланд тусгаж залруулах
4. МУЗГ-ын 153-р тогтоолоор батлагдсан “СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих, журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.7-д “Сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална” гэснийг мөрдөж ажиллах

Сумдын Сум хөгжүүлэх санд өгсөн дээрх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитаар нийт 2,692,199.5 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлснээс 3,580.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,573,481.3 мянган төгрөгийн албан шаардлага, 1,115,138.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийн орлогыг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.
2. Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль журмын дагуу үнэлээгүйгээс гомдол гарсан байна.
3. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, тус сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын дагуу аймгийн Засаг дарга ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй байна.
5. ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээнд дотоод аудитын алба хяналт тавьж ажиллаагүй байна.
6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
7. СХС-гийн 2017 оны орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй тооцож төлөвлөсөн байна.
8. 2017 онд СХС-д улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй, мөн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байснаас зээл нэмж олгогдоогүй бөгөөд нийт зээлийн 84.6% нь чанаргүй зээлийн ангилалд багтаж байна.
9. Нийт 16 зээлдэгчийн зээл, зээлийн хүүг дутуу төлүүлэн зээлийг хаасан, Баянтал сумын 3 зээлдэгчийн зээлийн гэрээ, холбогдох материал алга болсон байна.
10. СХС-гаас олгосон зээлийн дийлэнх нь зориулалтын дагуу зарцуулагдаагүй, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдаагүй, зээлдэгч тус бүрт хувийн хэрэг үүсгээгүй, баримт материалыг эмх цэгцгүй, үдэж архивласан байна.
11. Зээлдэгчийн хувийн хэрэгт хяналтын карт огт ашиглаагүй, нягтлан бодогчтой сар бүр тооцоо нийлж тулган баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайлан дахь тоон мэдээлэл үнэн зөв, бодитой илэрхийлэгдээгүй байна.
12. 2017 оны байдлаар сумдын СХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулаагүйгээс хяналт шалгалт хийгдээгүй байна.
13. Зээлийн эргэн төлөлтөнд СХС-ийн орон тооны бус зөвлөл хяналт тавьж ажиллаагүй, зээлдэгчийн судалгаа, мэдээллийн сан хийгээгүй, зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулаагүй байна.
14. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн Засаг дарга ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулах
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээнд дотоод аудитын албаар дамжуулан хяналт тавьж ажиллах

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад:

1. ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж батлуулах
2. ОНХС-гаар иргэдийн санал авч, эрэмбэлэгдсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх
3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгуулах
4. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ажлын чанарын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
5. ОНХС-гийн авлага, өглөгийг барагдуулж ажиллах
3. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Аймгийн орон нутгийн өмчийн газрын даргад:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль журмын дагуу үнэлгээг үнэн зөв хийж байх
2. Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгуулахдаа тогтоолд ажлыг бүрэн, үнэн зөв дүнгээр тусгуулах

Сумдын Засаг дарга нарт

1. Төсөл хөтөлбөрийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль журмын дагуу үнэн зөв үнэлж байх
2. ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн ажлыг батлуулах
3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгуулах
4. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээний явцад хяналт тавьж ажиллах
5. ОНХС-гийн авлага, өглөгийг барагдуулж ажиллах
6. СХС-гийн журмын дагуу орлогын бүрдүүлэлт, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах


7. Чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй зээлийг төлүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг тооцож ажиллах
8. СХС-ийн орон тооны бус зөвлөлийг холбогдох журмын дагуу ажиллуулах Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
9. СХС хариуцсан мэргэжилтнүүдэд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл болон урамшуулал олгох, уг сангийн журамд тусгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх
10. Нийцлийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүдэд:

1. Журмын дагуу зээлдэгчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангах, зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч тус бүрийн хувийн хэрэгт зээл, зээлийн хүү төлбөрийн хяналтын карттай болгох, холбогдох баримт материалыг эмх цэгцтэй хадгалах,
2. Сар бүр зээлийн эргэн төлөлт, хүү, алдангийн орлогыг зээлдэгч тус бүрээр нягтлан бодогчтой тооцоо нийлж баталгаажуулах, зээлдэгчийн хувийн хэрэгт хяналтын карт хөтлөх
3. СХС-гийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг гаргаж хэвших
4. Зээлдэгч болон зээлийн мэдээллийн санг бүрэн бүрдүүлж, Монгол банкны мэдээллийн санд оруулах,
5. Чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй зээлийг төлүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах
6. Холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн ХОХБТХ болон сумдын Засаг дарга нараас ирүүлсэн санал:

	ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 42000 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг, Утас/Факс: (046) 7054 3118, И-мэйл: zdfg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn	
Дуг. №. 30 №. 6 / 1344	<i>У. Батсайханд санал тавиланд тугана</i> <i>Адамс</i> 5/1/20
тантай _____-ны № _____-т	
Хүсэлт хүргүүлэх тухай	

Танай байгууллагаас аймгийн Орон нутгийн хөгжил сангийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар зарим ажлуудын чанар болон ашиглалтын үйл ажиллагаанд гарсан зөрчлийн талаар ирүүлсэн саналыг судалж үзээд доорх тайлбарыг хүргүүлж байна.

- 5-р сургуулийн гадна тохижилтын ажлыг Илчит сансар ХХК-иар аймгийн Орон нутгийн хөгжил сангийн 1 165 888 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Гүйцэтгэсэн ажлуудаас хогийн сав, тоглоомыг дутуу суурилуулсныг засварлах талаар тус компанид албан бичиг хүргүүлж, 2018 оны 12 дугаар сарын 10-ны дотор засварлуулахаар харилцан тохиролцсон.
- Аймгийн төв гудамж, талбайг телекамерийн системд холбох ажлыг аймгийн Орон нутгийн хөгжил сангийн 217,343,0 мянган төгрөгөөр Би Си Ти ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Камерийн систем болон камеруудад доголдол гарсаны дагуу чанарын баталгаат хугацааны засварын ажлыг гүйцэтгүүлэхээр албан бичиг хүргүүлсний дагуу 2018 онд 3 удаа ирж засвар үйлчилгээг хийсэн. Дашваанжил шатахуун түгээх станцын хажуу талын камерийн шилэн кабелийг нэг иргэн ажил үйлчилгээ явуулж байх үед тасалсныг засварлуулахаар албан тоотыг хүргүүлсэн бөгөөд одоо ажиллахгүй байгаа 5 камерийг засварлуулахаар тус компанид албан бичиг хүргүүлээд байна.
- Нийтийн эзэмшлийн гудамж тоглоомын талбайн тохижилтын ажлыг аймгийн Орон нутгийн хөгжил сангийн 75,846,3 мянган төгрөгөөр Өгөөмөрөн шанд ХХК-иар гүйцэтгүүлсэн бөгөөд тус ажлын хүрээнд хийгдсэн гэрэлтүүлэг нь гадны нөлөөний улмаас эвдэрч гэмтсэн тул ашиглалтыг хариуцсан байгууллага болох "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-т засварлах үүрэг чиглэл хүргүүлсэн.
- Сүмбэр сумын 5-р сургуулийн дотуур байрны чийрэгжүүлэлтийн танхимд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд худалдан авсан тоног

03 0347

төхөөрөмжийн үзүүлэлт техникийн тодорхойлолтыг харьцуулан үзэж хариуг хүргүүлэх болно.

5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын уулзалтын өрөө, хурлын заалны тохижилтын 9967,9 мянган төгрөгийн ажил нь тухайн үед хөрөнгө хэмнэж, зайлшгүй хийгдэх шаардлагатай байсан бөгөөд гүйцэтгэлийн чанар сайн болсон.

6. 2017 оны Орон нутгийн хөгжил сангийн төсвийн тодотгол 11 дүгээр сарын 06-нд хийгдсэн бөгөөд тендер шалгаруулалтыг зарлаж, богино хугацаанд худалдан авах ажлыг зохион байгуулсан тул ондоо багтаан бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж амжаагүй бөгөөд 2018 онд бүртгэлжүүлэх ажлыг 2017 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 59 тогтоолын дагуу зохион байгуулсан болно.

7. Өмнөх оны аудитаар авлага, өглөгийг барагдуулах зөвлөмжийн хүрээнд "Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд Хот хоорондын төв зогсоол барих ажил"-ыг гүйцэтгэгч Магнус солус ХХК-ний хаяг тодорхойгүй, холбоо барих боломжгүй байсан тул Шүүхэд нэхэмжлэл гаргаж, Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулж, оршин суугаа хаягийг тодорхой болгосон. Үүний дагуу засварын ажлыг гүйцэтгүүлэхээр удаа дараа албан бичгээр харилцан шийдвэрлэх талаар ажиллаж байгаа болно.

Иймд дээрх нөхцөл байдлыг судлан, шийдвэрлэнэ үү.

Хавсралт 24 хуудастай.

ДАРГА  Д.СОДНОМ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426, И-мэйл: shiveegovi.zdg@gmail.com

2018-11-29 № 4/912

танил _____-ийг № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлтэй танилцлаа. Үүнд:

1. "3 дугаар цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил"-ын баталгаат хугацаа дууссан, тус байгууллага дээрх тоног төхөөрөмжийг бүрэн бүтэн хүлээж авсан бөгөөд баталгаат хугацааны үед эвдэрч гэмтээгүй учир цаашид гарах урсгал засварын зардлыг эзэмшигч байгууллага хариуцна.

2. "Сумын төвийг камержуулах ажил" нь баталгаат хугацааны үед байгалийн хүчин зүйлийн улмаас зарим нэг камер гэмтэж байсныг гүйцэтгэгч компаниар засварлуулж байсан. Баталгаат засварын хугацаа дууссан тул цаашид камерын бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтлийг эзэмшигч байгууллага хариуцах болно.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



*Н. Батсайханд
Тайланг сахиалт
орлогч*
31/12

Ж.ЦЭВЭЭНДУЛАМ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА

42017 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр,
Утас: 7054 3249, И-мэйл: govsumber@gmail.com

2018.11.29 № 4/702

танил _____-ийг № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлтэй танилцлаа.

Аудитын тайланд тусгах санал байхгүй болно.

ОРЛОГЧ ДАРГА

Н.ХИШИГДОРЖ



*Н. Батсайханд
Тайланг сахиалт
орлогч*
31/12



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42040 Говьсүмбэр аймаг, Баянтал сум, Луу,
Утас: 9411 3190, <http://www.bayantai.gs.gov.mn>

2018. 11. 29 № 485

танай _____-ийг № _____-г

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нэгтгэлтэй танилцав. Аудитын дүгнэлтэнд санал болгоход сумын Соёлын төвд цэвэр бохир усны шугамд холбох 7,000.0 мянган төгрөгийн ажлыг гэрээ байгуулж "Чадварлаг залуус" бүлгээр хийж гүйцэтгүүлсэн бөгөөд үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа болно.

ДАРГА

Д.МӨНХ-ЭРДЭНЭ



*У. Батсайханг
Төрийн газрын
аудитын
Төрийн газрын
аудитын
Төрийн газрын
аудитын*
№8 ДГ 74 31/29



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42040 Говьсүмбэр аймаг, Баянтал сум, Луу,
Утас: 9411 3190, <http://www.bayantai.gs.gov.mn>

2018. 11. 29 № 485

танай _____-ийг № _____-г

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын 2017 оны Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн нэгтгэлтэй танилцав.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА

Д.МӨНХ-ЭРДЭНЭ



*У. Батсайханг
Төрийн газрын
аудитын
Төрийн газрын
аудитын
Төрийн газрын
аудитын*
№8 ДГ 67 31/29

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 4/25

Ч/Я

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн"-д хийгдсэн аудитын тайлан, илэрсэн зөрчлийн жагсаалт, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн"-д хийгдсэн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, тогтоогдсон акт, албан шаардлагыг барагдуулж, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2019 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJILITUSHAAL.doc

89072